

PAX MONGOLICA / PAX MONGOLORUM

Ц. Шагдарсүрэн*

*“Эдүгээгээс эхлэн харилцан ирж, очиж амар мэндээ эрилцэн ...
Сайнаар эетэн найрамдваас зохис...”*
“It is proper to maintain amity and exchange of visitors, starting from now”
Хубилай хаанаас Японы ванд илгээсэн албан захидал (1265)

Монголчууд энэ жил анхныхаа төр улс байгуулсаны 2220 жилийн ойг тэмдэглэж байна. Түүхийн энэхүү урт удаан хугацаанд монголчуудын дэлхийн түүхнээ нэг бус удаа онцгой байр суурь эзлэж, орчлонгийн жамаар мандах буурах бүхий л замыг туулсаар ирсэн билээ. Иймэд Монгол төр улсын гадаад харилцааны түүхийн туршлага нь зөвхөн Монгол гэлтгүй өдгөө цагийн дэлхийн олон улсын гадаад харилцааны практикт нэгэн адил хамаарна. Тэгээд ч олон орны монголч эрдэмтэд энэ түүхийг тал талаас нь нягтлан судлаж үнэлэлт дүгнэлтээ өгсөөр ирсэн билээ.

Ер нь судлагаанаас үзэхэд дэлхийн түүхийн явцад цэрэг дайны үйл ажиллагаа ноёрхосон цаг үе ямар ч улс оронд үлэмжхэн байсан гэдэгтэй хэн ч маргах аргагүй. Энэ явдал монголчуудад ч нэгэн адил хамаатай. Гэвч цэрэг дайны дараа, байгуулсан төр улсыг амар амгалан, урд удаан тогтноулах нь хаана ч гэсэн эрхэм чухаг зорилго болдог ажээ. Энэ тухай монголчуудын дунд *“Морин дээрээс төр улсыг байгуулах амархан, мориноос буугаад төр улсыг төвхнүүлэх хэцүү”* (*“It is easy to establish a State from the horse back, but it is difficult to settle the State off the horse back”*) гэдэг үг олон үеийн туршид хэрэглэгдсээр иржээ.

Хүн(нү) улс [Hun monarchy], Чингисийн байгуулсан *Хамаг Монгол улс* [Whole Mongolia, энэ нэр 1224-1225 оны Чингисийн чулуу бичиг (The Stele of Chinggis ~ Yisungge)-т анх тэмдэглэгдсэн байдаг] болон *Их Монгол улс* [The Great Mongol Empire, энэ нэр 1246 онд Гүюг (Guyug) хаанаас Ромын Пап ламтанд илгээсэн захидалын тамганд буй], түүний дараахи монгол төрт *Юан гүрэн* (Yuan Dynasty) зэрэг дэлхий дахинаа нөлөөтэй байсан Монгол төр улсын гадаад харилцааны бодлого өвөрмөц онцлогтой байсан хийгээд түүний туршлага нь орчин үед ч зохих ач холбогдолтой гэж үзэх учир холбогдол буй. Тэрхүү бодлого нь тухай тухайн төр улс урт удаан хугацаанд амар амгалан оршин тогтнох гадаад хүчин

* МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг судлалын тэнхим

зүйлийг бүрэлдүүлж ирсэн гэдгийг олон эрдэмтэд нэгэнт хүлээн зөвшөөрчээ. Тэрхүү гадаад бодлогын төвд бусад улс ороны үндэсний хэл бичиг (The national language and writing), шашин суртал (The religious beliefs), аж төрөх ёс (The mode of Production) зэргийг адил тэгш эрхээр хүлээн зөвшөөрөх явдал онцгой байр эзлэж байсан ажээ. Тэгээд ч олон судлагчид *The Pax Mongolica ~ Pax Mongolorum, La paix mongole, Religious Tolerance* гэх зэрэг тусгай нэр томъёог гарган хэрэглэсэн хэрэг¹.



1246 онд Гүюг хаанаас Ромын Пап ламд илгээсэн захидалын тамга
(2-3-р мөрд Их Монгол улс гэдэг үг буй)

¹) W. Kotwicz, *Les Mongols, promoteur de l'idée de paix universelle au debut du XIIIe siècle*, - *Rocznik Orientalistyczny*, Tom. XVI [1950], Krakow, 1953 [Эл бүтээлийн монгол орчуулга нь: Хэл зохиол судлал, IX боть, 20-р дэвтэр, Улаанбаатар, 1974, 205-214 талд буй]; Grzegorz Leopold Seidler, *The political doctrine of the Mongols*, - *Annales Universitatis Marie-Curie Sklodowska*, Lublin, Polonia, Vol. VI.7, 1959, pp. 249-277; Chantal Lemerrier-Quelquejais, *La paix mongole, Joug tatar ou paix mongol?* Paris, 1970; Stuard Legg, *The Barbarians of Asia*, New York, 1970/1995; 350 p. [Арван бөлөг бүхий энэ ном анх *The Heartland* нэрээр гарсан бөгөөд IX бөлөг нь *Pax mongolica* (282-320-р тал) гэдэг нэртэй]; Herbert Franke, *Pax Mongolica*, - *Die Mongolen*, von W. Heissig, C. C. Müller, Haus der Kunst München, 22. März bis 28. Mai 1989, ss. 54-57; Удо Б. Баркманн, "Pax Mongolica"-ийн талаар эргэцүүлэн бодохуй, - *Acta Mongolica*, Volume 3 (215), Ulaanbaatar, 2003, 77-83-р тал; Ts. Shagdarsyng, *Pax Mongolica / Pax Mongolorum*, - *Representing Power In Ancients Inner Asia: Legitimacy, Transmission, and The Sacred* (Edited by Isabelle Charleux, Gregory Depaplace, Robert Hamayon, and Scott Pearce), - *Studies on East Asia*, Volume 30 - Center for East Asian Studies, Western Washington University, Bellingham, Washington, 2010 [430 pp.], pp. 357-363.

Үүнээс үүдүүлэн энэ удаад дээрхи нэр томъёонд хамаарах монгол төрийн ямар ямар түүхэн баримт байдагийг цухас толилуулахыг хичээлээ.


Хүннү улсын Модэ Шан-юй хаан (Hunnu Emperor Modun Shan'yu)-аас х. т. ө. 176 онд Хан улс (Han Dynasty)-д илгээсэн захидал, 174 онд Хан улсаас ирүүлсэн хариу захидал зэргээс үзвэл лавтайяа тэр үед найрамдал, ах дүүгийн гэрээ (fraternal accord), амар амгалан амьдралыг үлэмж эрхэмлэсэн агуулга олонтаа дайралддаг. Энэ ташрамаар хэлэхэд монгол албан бичигт уламжлагдан хааны тодотгол болж хэрэглэгддэг “*мөнх тэнгэрийн хүчин-дүр...*” (“by the strength of eternal Heaven”) гэдэг хэллэгийн анхны хувилбар 176 оны энэ захидалд *Тэнгэрт тэтгүүлсэн (орос орчуулга нь: *Поставленный небом хуннуский Великий Шаньюй*) гэдэг хэлбэрээр байдаг хэмээн эрдэмтэд тусгайлан тэмдэглэсэн нь буй. Шан-юй-гийн захидалд, Хуан-ди (*Huan-di* or Han Emperor)-гийн амрыг эриж, нэгэнт тогтоосон найрсаг гэрээ харилцаа хил хязгаарын цэрэг ардын буруугаар тасарсаныг дурдаад өнгөрсөнийг мартаж, тасарсаныг залган, түрүүн байгуулсан гэрээ хэлэлцээрийн сэргээж, дайн самууныг зогсоон, цэрэг ардыг амрааж, агт морьдыг таргалуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Мөн энэ тухайд Хуанди-гийн зүгээс ямар нэгэн санал ирээгүй болохыг дурдаж нэг тэмээ, хоёр агт морь тэргүүтэнийг бэлэг болгож захидлын хамт илгээлээ хэмээжүхүй. Захидалд цааш нь: хүүхэд багачууд тааваараа торниж, хөгшид өтгөс амар жимэр насаа элээж, нийтээр хөөр жаргалтай аж төрөх болтугай! гэсэн байдаг.

Хоёр жилийн дараа 174 онд Хан улсын Хуан-ди төлөөнийхөө түшмэлээр явуулсан хариу захидалдаа Хүннү-гийн Их шан-юй хааны амрыг хүндэтгэлтэйгээр эрж, түүний энх амгалангийн тухай саналыг үгчилэн давтаж нэгэн адил бодолтой байгаагаа илэрхийлжээ. Захидалдаа үнэт хатгамал бүхий хувцас хунар (caftans), гоёл чимэг болон арван хэсэг магнаг (silk brocade with dragon designs embroidered in gold and silver), дөчин хэсэг торго (silk), гучин хэсэг эрдэнийн чулуу тэргүүтэнийг бэлэг болгож барив гэж дурдсан байдаг.

Хуан-ди хариу захидалдаа бас тогтоосон гэрээ хэлэлцээр, ах дүүгийн ёсыг хүннү нарын зүгээс эвдсээр ирсэн хэмээн нэмэн тэмдэглэсэн нэгэн зүйл байдаг нь анхаарал татна. Энэ нь хятад түмэн Жин (Qin, 221 – 207 BC), Хан (Han, 202 BC – 220 AD) болон Минг (Ming, 1368 – 1644 AD) улсыг дамжуулан бараг 2000 жилийн турш байгуулсан дэлхийн гайхамшигийн нэг – Цагаан хэрэмийг Хан улсын үед хамагийн эрчимтэй үргэлжлүүлсэнтэй холбоотой буй заа. Хэрэвзээ умардын нүүдэлчидийн сөрөг нөлөө байгаагүй бол дэлхийн хэмжээний энэхүү түүхэн гайхамшигт байгууламжийг цогцлоох байсан уу? гэдэг асуулт ч гарч болно. Дээрхи хоёр захидалын хятад бүрэн орчуулга *Хан улсын түүх* (“*History of Han Dynasty*”)-ийн 94-р бөлөгт буй.


Чингис хааны үүсгэн байгуулсан Их монгол улс (The Great Mongol Empire)-ын үеэс нэгэнт байгуулсан Их улсыг төвхнүүлж, урт удаан амар жимэр тогтнуулахад зөвхөн улсын дотоодод төдийгүй гадаад дахинаа чиглэсэн бодлогоос хамаарна гэдгийг сайтар мэдэж, элч төлөөлөгчийг нь ёсон бусаар хөнөөх зэргээр эсэргүүцээгүй тохиолдолд цэрэг зэвсэгийн хүч хэрэглэхийг төдий л уридал болгодоггүй байсан тухай сүүлийн үед гадаадын болон монголын түүхчид түлхүү бичих болжээ. Үүнийг батлах нэг бус жишээ баримтыг тухайн үеийн үйл ажиллагаа, хаадын зарлиг болон гадаад харилцааны албан

захидлуудаас олж үзэж болно. 1246 онд Гүюг хаанаас Ромын Пап (Pope Innocent IV) ламтанд явуулсан хариу захидал энэ бүхнийг батлана. Үүнээс Ромын Папын ирүүлсэн захидалд монголчуудыг шашинаа огоорч христус шашинтан бол гэснийг олж мэдэх болно. Бас Монголоос илгээсэн элчин төлөөлөгчийг хороосон гэдгийг мэдэж болно. Юан гүрэн (Yuan Dynasty)-ий үед аль нэгэн нөлөөтэй үндэстэний бэлэн бичгийг авч хэрэглэлгүй, 1269 онд дөрвөлжин бичиг (Square script ~ 'Phags-pa script) хэмээх бичгийг цоо шинээр зохион төрийн бичиг (official script) болгосон нь улс төрийн хувьд зөв шийдэл байжээ. Энэ бичиг нь монгол, хятад, төвөд, самгард (sanskrit), түрэг зэрэг Юан гүрэний бүрэлдэхүүн дэхи олон үндэстэний хэлээр бичих боломжтой, түүнийг батлах бичгийн дурсгал бидний үед хүрэлцэн иржээ.



1577 онд Түмэдийн Алтан хаанаас шарын шашины тэргүүний III дүр (reincarnation)-д “Далай лам” хэмээх цол олгосон 100 лангийн алтан тамгын дардас²

[Дөрвөлжин бичгээр төвөд хэлээр бичсэн энэ тамгаас эхлэн *Далай лам* гэдэг нэр томъёо дэлхий нийтээр хэрэглэгдэх болжээ.]





²⁾ Tch. Altanguerel, Ts. Chagdarsureng, *Note sur un diplôme bilingue*, - Rocznik Orientalistyczny, Tom. XXXV, z. 2, Warszawa, 1973, pp. 33-42.



Дөрвөлжин бичгээр гурван хэлээр дарсан тамга

[a. Өлзийт хааны захианы тамга (монголоор); b. Их шүлэгч Ли Бай-н зураг дээрхи тамга (хятадаар); c. Түрфанаас олдсон монгол бичиг дээрхи тамга (түрэгээр)]

Тэгээд ч хааны зарлиг тэргүүтэнийг монгол хэлээр үйлдэж бусад үндэстэний хэл хэлээр нь хавсарган тархааж байсан ажээ. Энэ бол олон үндэсний хэл болон бичигийг нь эрх тэгш үзэж ирсэний батлагаа болно.



Монгол бичгээрхи Хубилай хааны луу жил (1268)-ийн зарлиг, түүний хятад орчуулга



Дөрвөлжин бичигээрхи Буянт хааны хулгана жил (1312)-ийн зарлиг, түүний хятад орчуулга

Ромын папад илгээсэн захидлаа персээр, Францын Гоо Филипп ван (French King Beautiful Philip)-д илгээсэн захидлаа монголоор, Японы ванд илгээсэн захидлаа хятадаар гэх мэтээр гадаад дахинд илгээх захидалаа тухайн улсад ойлгомж, хүртээмжтэй хэлээр нь илгээдэг байжээ.

Юан гүрэний удаа дараагийн хаадын монгол болон дөрвөлжин бичигээрхи зарлигийн гол агуулга нь тэр үеийн голлох шашин – будда (Buddhism), бомба (Daoism), несториан (Nestorian ~ Christian), лал (Islam)-ын шашинтаныг төрийн зүгээс адил тэгш үзэж, албан татвараас чөлөөлөх зэргээр тусгай эрх олгож байсаны батлагаа болж өгдөг.

Мөн тэдэнд эрхээ хэтрүүлж үүргээ үл умартахыг чандиан анхааруулсан байдаг нь хууль цаазын үүднээс эрх, үүрэг хоёрын нэгдэлийг хангасан явдал байжээ. Зарлиг бүрт Чингисээс эхлэн дараа дараагийн хаадын нэрийг дурдсан байдаг нь уг зарлигийн утга учир Чингис хааны үеэс улбаатай болохыг харуулах боловч олон шашинтаны эрхийг улам бүр өргөтгөж байсан байдал тодорхой харагддаг. Энэ бүхэн бол монгол төрийн бодлого уламжлалт чанартай байсныг харуулж байгаа юм. Их монгол улсын үед Чингисээс эхлэн удаа дараагийн хаадын дэргэд олон шашинтан-түшмэл төрийн албанаа хүчин зүтгэсээр байгаа нь нэн гайхалтай хэмээн тэр үед монгол газар хүрэлцэн ирсэн Плано Карпин зэрэг европ жуулчид тэмдэглэлдээ дурджээ.

“Монголын нууц товчоон” (“The Secret History of Mongols”) болон Ази, Европын олон улсад илгээсэн албан захидалыг үзэхэд эв найртай харилцаа, энх тайвангийн санаа голлох болсон нь цаг хугацааны хувьд нэгэнт байгуулсан төр улсын амар амгаланг эрхэмлэх болсонтой холбоотой гэж түүхчид үздэг байна. Үүнд холбогдох гурван баримтыг товч төдий жагсаан толилуулая.

☉ “Монголын нууц товчоон”-ы 279-р зүйлд:

“Өгөөдэй хаан өгүүлэрүүн:

Чингис хаан эцэгийнхээ зовон байгуулсан улсыг бүү зовооё.

Хөлийг нь хөсөр, гарыг нь газар талбиулж жаргуулая...”


(Cgydei khaan said: “We shall not cause suffering to the nation that our father Cinggis Qa'an established with so much toil. We shall make the people rejoice, causing to rest Their feet upon the ground, Their hands upon the earth...”)

☉ 1265 онд Хубилай хаанаас Японы ванд илгээсэн албан захидалд:

“Эдүгээгээс эхлэн харилцан ирж, очиж амар мэндээ эрилцэн ...

Сайнаар эетэн найрамдваас зохис...”

(“It is proper to maintain amity and exchange of visitors, starting from now”)



1265 онд Хубилай хаанаас Японы ванд илгээсэн захидал

☉ 1305 онд Ил хаан Өлзийтөөс Францын Гоо Филипп ванд илгээсэн захидалд:

“...үнэнхүү зохилдохоос (илүү) сайн (юм) юун ахуй...”
 (“...nothing is better than being compatible...”)



Dschingis Khan und seine Erben, Das Weltreich der Mongolen, München, 2005, (432 s) s.281


1305 онд Өлзийт хаанаас Францын Гоо Филиппэд илгээсэн
захидлын төгсгөл хэсэг

[эхнээсээ 7-8-р мөрт бидний авсан эшлэл байгаа]

Дээр өгүүлсэн нийтийн энх тайванг эрхэмлэсэн энэ бүх санаа нь Чингис хааны Их Монгол улс (The Great Mongol Empire)-аас үүдэлтэй гэж үзэх бүрэн үндэстэй. Тэрхүү уламжлал нь Чингисийн үр ач нарын үед бичигт тэмдэглэгдэж, бас зарим нь монгол түмний аман уламжлалаар өдгөө хүртэл хадгалагдсаар бөлгөө. Тухайлбал: цаг хугацааны хувьд түрүүн олдсон ийм нэг баримт гэвэл энэ хэр Истамбул хотоос дөрвөлжин бичгээр олдсон, Хубилай хааны хөвгүүд дүү нартаа захисан гэх сургаал (Najm'al-'Ajaib) болно. Уг бичвэрийг эдүгээчлэн тодруулан тайлбарлаж сийрүүлвэл дараахи мэт болно.

“Хубилай хаан(ы) зарлиг болоруун: Та урагууд, Миний моноо хойно [=надаас хойш] улс иргэнийг хурааваас [=хураая] гэвээс биеийг нь хурааталаа

[=хураахаас өмнө] сэтгэлийг нь хурааваас [+ зохино]. Сэтгэлийг нь хураацаа
[=хураах бөгөөс] биес нь хаа үдхүн [=~ одох]...”



D. Tumurtogoo, ... *Mongolian Monuments in 'Phags-pa Script*, Taipei, 2010, p. 262

Дөрвөлжин бичигээр үлдэж ирсэн Хубилай хаанаас хөвгүүд дүү нартаа
сануулсан сургааль

Энэ сургаалийг Чингис хаанаас үүдэлтэй гэж дээр тэмдэглэсэнээ одоо тодруулан
тайлбарлая. Дөрвөлжин бичгээр бидний үед хүрэлцэн ирсэн Хубилайн хэмээх энэхүү
сургааль нь харьцангуй сүүл үеийн буюу Лувсанданзаны “Алтан товчи”-д дараахи
байдлаар тохиолдоно. Үүнд:

...Чингис хаан тэр аян аялаж,
харьж айсухуйд Алтан-хиа
дээр буусанд хөвгүүдээ
соён зарлиг болурун
Мөн хойно та
Өндөр уул давж
Өргөн мөрөнийг гэтэлж,
Сур дөрөөгөөн сунатал,
Төмөр дөрөөгөө дөлөртөл
Жийж явурун та.

*Олон улсыг барису (+ хэмээх бөгөөс),
Бие(+ийг)-инү хураатал (= хураахаасаа),
Сэдхилийг-инү хураагтүн.
Сэдхилийг-инү хурааваас,
Бие-инү хамигаа одху
хэмээгсэн ажугуу...*

хэмээн Чингис хаан зарлиг болсон гэж илүү дэлгэрэнгүй, илүү тодорхой өгүүлсэн байдаг³. Үүний англи орчуулга нь:

*...Henceforth you will pass high mountains
Cross over wide rivers,
Execute distant campaigns,
Stretching your legs in the stirrups
So forcefully that their straps will stretch and their flaps will tear apart.
You will rule a host of lands,
Having conquered the body, conquer the mind,
If the spirit is overcome,
The body will not depart anywhere...⁴*

Бас нэгэн зүйл баримт: Олон үеийн турш монголчуудын дунд уламжлал болсон гэж дээр өгүүлсэн “*Морин дээрээс төр улсыг байгуулах амархан, мориноос буугаад төр улсыг төвхнүүлэх хэцүү*” (“*It is easy to establish a State from the horse back, but it is difficult to settle the State off the horse back*”) гэдэг хэллэгийн уг гарлыг нэхэн үзвэл мөн л Чингис хааны Их Монгол Улсын төрийн бодлоготой, бүр тухайлбал: Чингис хаан болон 1218 оноос монгол төрд хүчин зүтгэсэн монгол угсааны хятан гаралтай Елюй Цуу-цай-н нэртэй холбоотой байдаг. Уг хэллэг тэр үед “...*морин дэл дээр байгуулсан улсыг морин дээрээс жолоодож болохгүй...*” (“*It is must not, on the horse back, to settle a State, established from the horse back*”) гэдэг хувилбараар XVII зууны монголын түүхэн сурвалжид дайралддаг.

Тэрхүү монгол сурвалжид Елюй Цуу-цай (энэ хүнийг *Монголын нууц товчоон*-д гардаг Цуу мэргэн мөн хэмээж Цэмбэл гүүш тэмдэглэсэн) зарим улсаар жишээ авч, эзлэсэн улс орныг тухайн улс орныхи нь аж төрөлд нийцсэн **хуули**-аар захирах хэрэгтэй хэмээн зөвлөгөө өгсөн гэдэг мэдээ буй. Энэхүү тухайн орны **хууль** гэдэг нь одоогийн бидний **хууль** (law) гэдэг ойлголтоос хамаагүй өргөн, тухайлбал: тухайн ард түмний аж төрөл, ёс заншил, хэл бичиг, шашин суртал цөм багтана. Үүний дээр ямар ч үед ямар ч хаан, ерөнхийлөгч, ерөнхий сайдад зөвлөгч байдаг, тэд нь зөвлөдөг ч тухайн шийдвэрийг зөвлөгч биш, хаан юм уу, ерөнхийлөгч юм уу, ерөнхий сайд нь тунгаан бодоод гаргадаг тул Елюй Цуу-цайн зөвлөгөө нь Чингис хааны нэр хүндийг бууруулсан зүйл огт биш. Тэгээд ч энэхүү өгүүлэлд монголчуудын *Pax Mongolica*-д холбогдох

³) Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршибуй, Оршил бичсэн Ш. Бира, Улаанбаатар, 1990, 99 а.-99 б.

⁴) Shagdaryn Bira, *Mongolian Historical Writing from 1200 to 1700*, Translated from the original Russian by John R. Krueger and revised and updated by the author, Second Edition, - Studies on East Asian, Vol. 24, Western Washington University, 2002 [249 pp], see. p. 182.

төрийн бодлого нь улсын дотоод болон гадаад дахи бусад ард түмэний шашин суртал, хэл бичиг, аж төрлийг тааваар нь байлгахад онцгой чиглэж байсан тухай гадаад харилцааны бичиг, хааны зарлиг тэргүүтэн албан баримт түшин толилуулахыг хичээсэн бөлгөө.

Хамагийн сүүлд тэмдэглэлгүй орхих аргагүй бас нэгэн зүйл буй. Монголчуудын байгуулсан төр улсын энх амгаланг эрхэмлэсэн энэхүү *Pax Mongolica* бодлогыг санаачлагч нь тухайн үедээ үлэмж нөлөөтэй байсан монголчууд байлаа. Гэвч үйл явц нь зөвхөн нэг талынхи буюу зөвхөн монголчуудынхи байгаагүй гэж үзэх үндэс буй. Үүнд: уг бодлого Их Монгол Улс (The Great Mongol Empire) болон Юан гүрэн (Yuan Dynasty)-ээр хязгаарлагдалгүй зэргэлдээхи улс үндэстэний эрх ашигт нэгэн адил нийцэж хүлээн зөвшөөрч байсаныг 1362 онд [Х]Индү ван (Prince Hindu)-гийн дурасхалд зориулсан 54 мөр томоохон гэрэл)⁵ хөшөөний бичээст буй⁶

... Чингис хааны

Эрийг үл зовоон

Агтыг үл хөлөргөн

Сайнаар орж хүчин өг(өх)...

(It was noted...."no arms for genius Chinggis Khan's warriors, no sweat for horses" (in mongolian: "Суут Чингис хааны эрийг үл зовоон, агтыг үл хөлөргөн")⁷, we are giving up voluntarily and are ready to serve to him.)

⁵ Орчин цагийн монгол хэлнээ *гэрэлт хөшөө* гэдэг үг буй бөгөөд нэг бус хүн яахаараа хөшөө гэрэлтэй байдаг билээ хэмээн гайхдаг нь оросжин кирилл шинэ үсгийн бичилгээс үүдсэн эндүүрэлтэй холбоотой. Өөрөөр хэлбэл угтаа *гэрээ, гэрэчи, гэрэл* гэх зэрэг олон үгтэй язгуур нэг, *гэрэ* гэж богино эгшигээр төгсдөг, утга ялгах үүрэг бүхий, байх ёстой —э эгшигийг нь хассантай холбоотой. "*Монголын нууц товчоон*"-д уг үг *гэрэ* гэдэг хэлбэрээр олонтаа тохиолддог. *Хэл -тогтолцоо* гэдэг хэлшинжлэлийн зарчимаар *хан ~ хана, баг ~ бага* гэх мэтээр богино эгшиг утга ялгах (буюу авиалбарын) үүрэгтэй. Үүнийг чухамдаа хэлний шинжлэлд байдаггүй "*хоолойн н, хэлний н*", "*хоолойн гэ, хэлний гэ*" гэх мэтээр тусхайлан тайлбарлах аргагүй. *Гэр ~ гэрэ* гэдэг хоёр үг ч зарчимын хувьд нэг гэсэн үг. Тэгээд ч буриад нөхөд буриад хэлнийхээ тольд энэ үгийг *гэрэ*, нөгөө *орон гэр* гэдэг утга бүхий үгийг *гэр* хэмээн ялгаж зөв бичсэн байгаа. Харин бид орос кирилл шинэ үсэгт тэрхүү байх ёстой, утга ялгах —э эгшигийг үгүй болгож *гэр* гэж бичих болсоноор мөнөөхи *гэрэ* гэдэг үг мартагдаж, үүнээс үүдэн баатарлагын тууль дахи *гэрэ мэт гэрэлтэй, туурга мэт туяатай* гэдэг хэллэгийн *гэрэ, туурга* (энэ үг *туяа, туяарах, тусах, туурах* гэх зэрэг үгтэй язгуур нэгтэй болохоос биш *хана туурга*-тай огт хамаагүй.), *Гэрболод* гэдэг түүхэн хүний нэрийн *Гэрэ* гэдэг үгийг *гэр орон, хана туурга* мэтээр ташааран ойлгоход хүрчээ. Тэгээд ч туулийн дээрхи хэллэгийг ташааралдаа нийцүүлэн *мэт* гэж байсан үгийг *нэвт* болгон, *гэр нэвт, туурга нэвт* гэж муйхарлан "засах"-ад хүрчээ. Энэ бүхэн зөв бичихзүйн санамсаргүй нэгэн алдаа нь хэлбэр судлал буюу үг бүтэх ёсон (morphology), зөв бичихзүй (orthography), зөв дуудахзүй (orthoepy), утгазүй (semantics), үгийн сан (lexicology), найруулгазүй (stylistics) гэх мэтээр хэлний төвшин төвшинд халдварладагийн нэг баримт мөн.

⁶ Tumurtogoo D [with the collaboration of Cecegdari G], *Mongolian Monuments in Uighur-Mongolian Scripts* (XIII-XIV Centuries), Introduction, Transcription and Bibliography, Language and Linguistics Monograph Series A-11, Institute of Linguistics, Academia Sinica, Taipei, 2006, [722 pp.], see p. 29.

⁷ Энэхүү монгол өвөрмөц хэллэгийн англи орчуулгын тухайд доктор Д. Баярсайхан тусласан болно.

тухай өгүүлсэн хэсгээс бэлхэнээ харж болно. Энэхүү эрийг үл зовоон, агтыг үл хөлөргөн гэдэг хэллэгт буй эр гэдэг үг нь, тухайн цагтаа 16 – 60 насны бүх эр хүн цэрэг эрд тооцогдож байсан тул *цэрэг эр* (warriors) гэсэн утгыг давхар агуулж, уг хэллэг бүхэлдээ хүн морьгүй цөм амар амгалан аж төрөх гэдэг утга илэрхийлэх бөлгөө.

Энэ бүхэнээс үзвэл Монгол туургатаны байгуулсан төр улсын дотоод болон гадаад бодлого нь эхин үеэсээ л амар амгалан амьдралыг төвхнүүлэхэд үлэмж анхаарч, түүний нэг гол шижим нь олон үндэстэний хэл болоод бичиг, шашин болоод суртал, аж төрөл болоод амьдралынх нь хэв маягийг **өөрчлөлгүй, хэвээр нь эрх тэгш хүлээн хэрэгсэх** (Tolerance) **явдал** гэж үзэж ирсэн байдал бэлээхэнээ харагддаг.

Сүүлийн үед гадаад дахины олон монголч эрдэмтэн аж төрөх ёсон хийгээд мэдээллийн хувьд өдгөөгийн даяарших үйл явц Чингис хааны үед эхлэсэн хэмээн үзэж байгаа ч баримтлаж ирсэн зарчим нь өөр байсан гэдгийг тэмдэглэлгүй орхих аргагүй. Үүнд: Өдгөөгийн даяаршил гэдгийн мөн чанарыг үзвэл их гүрэний зүгээс өөрийн хэл бичиг, шашин суртал, соёл боловсрол, аж төрөх ёсыг бусад бага буурай улс орны тухайд хүчээр тулган хүлээлгэхийг чармайдаг нь нэгэнт нууц бус болж, эсэргүүцэл тэмцэл ч гарсаар буйг бид мэдэх болжээ. Харин Чингисийн үед “*монголжин дураар аж төрөх*” (to live by way of Mongolian life) гэдэг жишигээрээ бусад олон үндэстэний хэл болоод бичигийг хүлээн хэрэгсэх (Language and Writing Tolerance), амьдрал болон аж төрөх ёсыг хүлээн хэрэгсэх ((Life Tolerance or way of life Tolerance), шашин сурталыг хүлээн хэрэгсэх (Religious Tolerance) нь нийтийн энх амгалангийн үүд хэмээн үзэж ирсэнээрээ эрс ялгаатай.

Харин ийм зарчим хожидын аль нэгэн их гүрэний гадаад тийшээ хандсан бодлогод огт давтагдаагүй гэж бодогдоно. Ямар ч атугай сүүлчийн хэдэн зууны туршид Монгол руу хандсан их гүрнүүдийн бодлогод лав гарсангүй.

SUMMARY

The domestic and foreign policy of the Mongols has, from earliest times, privileged the establishment of peaceful living conditions, a clear example of which is the principle of tolerance for the language, religions and beliefs, and livelihoods and customs of the many peoples governed by the Mongols.

Many foreign Mongolists have argued in recent years that the process of globalization, taken as a way of life and in terms of communication, began with the period of Chinggis Khaan, though the governing principles of each period are distinct. Contemporary globalization is clearly based on the principle of empires forcing their on languages, religions, culture, and ways of life onto smaller, weaker countries, leading to some forms of resistance. Yet the period of Chinggis Khaan was extremely different, being characterized by a commitment to *live by way of Mongolian life*, viewing language and writing tolerance, life tolerance or way of life tolerance, and religious tolerance as ensuring social peace and stability.